

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБАНЫ
2025 ОНЫ 02 ДУГААР САРЫН
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАЛТЫН ТУХАЙ ТАЙЛАН

2025.03.10

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 02/15 дугаар тогтоолоор батлагдсан дүүргийн Төсвийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөөг хүлээн авч боловсруулан төрийн худалдан авах ажиллагааны цахим системд мэдээлэн ажиллалаа.

Батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам зааварт нийцүүлэн төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулан ажиллаж байна.

1.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны **2 дугаар** сарын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн талаар: /санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр/

а. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Дүүргийн ИТХ-аас дүүргийн төсвийн хөрөнгөөр нийт 83,643.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтын 113 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан. Захиалагчаас захиалгын хуудсын дагуу зарим төсөл арга хэмжээ багцад хуваагдаж батлагдсантай холбоотойгоор төсөл арга хэмжээний тоо нэмэгдэж 121 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд өөрчлөлт орсон.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн	585.7	5
2	Тендерийн материал хүлээн авч байгаа	16064.6	35
3	Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа	34704.6	16
4	Үнэлгээний шатанд	164.7	3
5	Захиалга ирээгүй, үнэлгээний хороо байгуулагдсан	870.0	6
6	Захиалга ирсэн, үнэлгээний хороо байгуулагдаагүй	315.2	4
7	Захиалга ирээгүй, үнэлгээний хороо байгуулагдаагүй	30938.4	52
ДҮН		83643.2	121

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 48.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлснээр 40.8 сая төгрөгийн төсвийн хэмнэлт үүсгэн ажиллалаа.

б. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжих 1798.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл арга хэмжээ батлагдсан.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Захиалга ирээгүй, үнэлгээний хороо байгуулагдаагүй	1798.5	3
ДҮН		1798.5	3

в. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих /худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн/ бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

2025 оны 2 дугаар сарын байдлаар улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих буюу худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирсэн 2 төсөл арга хэмжээ байна. Үүнд:

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/187 захирамжийн дагуу нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжих 3552.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 багцтай “Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадны зураг төсөв, засварын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг)” төсөл арга хэмжээ, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/186 захирамжийн дагуу нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжих 1760.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажил (Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг)” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх тус тус шилжиж ирсэн.

Дээрх эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулан ажиллалаа.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Тендерийн материал хүлээн авч байгаа	3552.0	7
2	Захиалга ирээгүй, үнэлгээний хороо байгуулагдаагүй	1760.0	1
ДҮН		5312.0	8

г. Дүүргийн төсвийн бусад эх үүсвэрээр хэрэгжих бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт:

Дүүргийн Засаг даргын захирамжаар дүүргийн төсвийн бусад эх үүсвэрийн хөрөнгөөр санхүүжих тухайн цаг үеийн шинж чанартай худалдан авалтыг зохион байгуулахаар 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 18035.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 23 төсөл арга хэмжээ тусгагдсан.

2025 оны 02 дугаар сард төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт орж 20552.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 27 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр өөрчлөгдсөн. Үүнээс 2025 оны 2 дугаар сард “Шатахуун худалдан авах” 410.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, “Шингэн хог хаягдал бохирын тусгай зориулалттай тээврийн хэрэгсэл” 80.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Сүхбаатар Дэвшил ОНӨААТҮГ-т шилжүүлснээр 20062.2 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр өөрчлөгдсөн.

Захиалагчаас захиалгын хуудсын дагуу зарим төсөл арга хэмжээ багцад хуваагдаж батлагдсантай холбоотойгоор төсөл арга хэмжээний тоо нэмэгдэж **28** төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд өөрчлөлт орсон.

№	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	Төсөвт өртөг (сая. Төг)	Төсөл арга хэмжээний тоо
1	Тендерийн материал хүлээн авч байгаа	6698.3	8
2	Захиалга ирээгүй, үнэлгээний хороо байгуулагдсан	650.0	2
3	Захиалга ирээгүй, үнэлгээний хороо байгуулагдаагүй	12713.9	18
ДҮН		20062.2	28

1.2 Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн эсэх талаар:

2025 оны **2 дугаар** сарын байдлаар тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй хугацаанд бүрэн хийсэн байна.

1.3 Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчил, түүнийг хэрхэн залруулсан талаар:

2025 оны **2 дугаар** сарын байдлаар худалдан авах ажиллагааны талаар зөрчил гараагүй болно.

1.4 Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдлын талаар:

2025 оны **2 дугаар** сарын байдлаар худалдан авах ажиллагааны талаар 2 гомдол гарсан байна. Үүнд:

- 992.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг засвар, арчлалт хамгаалалт, үйлчилгээ /Төв авто зам дагуух/ төсөл арга хэмжээний тендерийн материал хүлээн авч байх хугацаанд Монополын эсрэг газарт гомдол ирсний дагуу холбогдох материалыг хүргүүлэн ажилласан болно.
- 1672.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг засвар, арчлалт хамгаалалт, үйлчилгээ /Орон сууц, гэр хороолол, гудамж зам талбай/ төсөл арга хэмжээний тендерийн материал хүлээн авч байх хугацаанд Монополын эсрэг газарт гомдол ирсний дагуу холбогдох материалыг хүргүүлэн ажилласан болно.

1.5 Ногоон худалдан авалт болон дотоодын бараа худалдан авсан талаар:

2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 1750.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээний ногоон худалдан авалт зохион байгуулахаар тусгагдсан.

2025 оны **2 дугаар** сарын байдлаар 500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод бут худалдан авах /хавар/” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлаж, тендерийн материал хүлээн авч байна.

ХОЁР. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМИЙГ АШИГЛАСАН ТАЛААР

2.1 Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалтын тоо, хувь болон системийн талаар:

2025 оны **2 дугаар** сарын байдлаар төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан захиалагчаас ирүүлсэн ажлын даалгаврын хүрээнд ДТХО, дүүргийн хот тохижуулах зардал болон НТХО, НОНХСангийн хөрөнгөөр санхүүжих нийт 61769.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 74 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

2.2 Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн ашиглалт болон утхайн жилд худалдан авсан бараа, үйлчилгээний тоо, мөнгөн дүн, гэрээний хэрэгжилтийн талаар:

2025 оны 2 дугаар сарын байдлаар ерөнхий гэрээний журмын дагуу хийсэн худалдан аварт байхгүй болно.

ГУРАВ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ:

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх дүгнэлт:

ДИТХ-ын тогтоолоор 2025 онд дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын болон нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний хүрээнд Дүүргийн Засаг даргын захирамжаар нийт 12 удаа үнэлгээний хороо байгуулагдан худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

2025 оны 2 дугаар сарын байдлаар худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүн дараах байдалтай байна.

*Төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны хэрэгжилт
(2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар, сая төгрөг)*

Үзүүлэлт	ДТХО		ДОНХС		БУСАД		НТХО, НОХС		НИЙТ		ЭЗЛЭХ ХУВЬ	
ХАА-г бүрэн зохион байгуулсан	5	585.7							5	585.7	74	46.3%
Тендерийн шатанд, дахин зарласан	35	16,064.6			8	6,698.3	7	3,552.0	50	26,314.9		
ТББ боловсруулж байгаа, дахин зарлах	16	34,704.6							16	34,704.6		
Үнэлгээний шатанд	3	164.7							3	164.7		
Захиалга ирээгүй, ҮХ байгуулагдсан	6	870.0			2	650.0	1	1,760.0	9	3,280.0	9	5.6%
Захиалга ирсэн, ҮХ байгуулагдаагүй	4	315.2							4	315.2	4	2.5%
Захиалга ирээгүй, ҮХ байгуулагдаагүй	52	30,938.4	3	1,798.5	18	12,713.9			73	45,450.8	73	45.6%
ДҮН	121	83643.2	3	1798.5	28	20,062.2	8	5,312.0	160	110,815.90	160	100%

ДӨРӨВ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ:

Дүүргийн Засаг даргын баталсан Худалдан авах ажиллагааны 2025 оны жилийн төлөвлөгөө, зохион байгуулалтын явц, үр дүнгийн талаарх мэдээ тайланг 2025 оны 2 дугаар сарын байдлаар www.tender.gov.mn, дүүргийн ЗДТГ-ын www.sbd.gov.mn, www.shilendans.gov.mn, www.report.ub-procurement.mn цахим хуудсуудад, мөн дүүргийн худалдан авах ажиллагааны албаны мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд нээлттэй мэдээллээ.

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА